



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/615

Улаанбаатар хот

Цагийн хуваарийн зөвлөл
байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4.4, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журам”-ын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа нисэх буудлуудад хуваарьт нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчдийн нислэгийн цагийн хуваарийг хүлээн авах цагийн хуваарийн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

Тэргүүн дэд дарга

Нарийн бичгийн
дарга:

Нисэх буудлуудын удирдах газрын Бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн тээвэр зохион
байгуулалт, зорчигч үйлчилгээний
мэргэжилтэн

Гишүүд:

Нисэх буудлуудын удирдах газрын дарга

Нисэх буудлуудын удирдах газрын дэд
дарга

Агаарын тээврийн бодлого, төлөвлөлтийн
газрын дарга

Агаарын навигацийн бодлого,
зохицуулалтын газрын дарга

Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний
албаны дарга

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын
захирал

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын
үйлдвэрлэл хариуцсан дэд захирал


Нисэх буудлуудын удирдах газрын Бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлын
Үйлдвэрлэлийн төлөвлөлт, зохицуулалтын
хэлтсийн дарга

Агаарын тээврийн бодлого, төлөвлөлтийн
газрын Агаарын харилцааны тасгийн ахлах
мэргэжилтэн

2. Цагийн хуваарийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга /Б.Алтанцом/-д даалгасгай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН